

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.11.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид энэ сард 1 удаа хуралдаж 3 асуудал хэлэлцэн 3 тогтоол баталлаа. Үүнд:

1.Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг хэлэлцээд аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн явцыг 82.3 хувиар дүгнэн үндсэн чиглэлийн арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг иргэд олон нийтэд таниулж, хөтөлбөрийн хүлээгдэж буй зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

2.Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг 3 бүлгийн 152 зүйл заалттайгаар баталж, үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай зорилт арга хэмжээний төсвийг 2020 оны аймгийн төсөвт тусган ажиллахдаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудад шаардлагатай тооцоо судалгаа, зураг төсвийг нь харгалзан ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

3.Сэлэнгэ аймгийн 2019 оны төсөвт урьд оны үлдэгдэл нэмж батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 131 сая төгрөг, тендерийн үйл ажиллагааны явагдаагүй, зураг төсвийн асуудал шийдэгдээгүй 3 ажлыг хойшлуулж 233 сая төгрөгийг шилжүүлэн аймгийн 2019 оны төсөвт нэмж төсвийн зохицуулалт хийж баталлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид энэ сард 1 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэн 10 тогтоол баталлаа. Үүнд:

-Хуралдаан зарлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын ээлжит XVI хуралдааныг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хуралдуулж аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн явцын тухай, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, Аймгийн 2019 оны төсөвт урьд оны үлдэгдэл нэмж батлах тухай асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосон.

-Сум орон нутгийн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хүрээнд айл өрхийн түлшний хэрэгцээнд зориулж ойн цэвэрлэгээний ажлаар бэлтгэсэн түлээний модыг ойн нөөцгүй Сайхан, Орхон, Орхонтуул сумд руу тээвэрлэхийг Хүдэр сумын ойг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдэд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртлэх хугацаагаар зөвшөөрөв.

Мөн “Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталж, Атар газар эзэмшсний 60 жилийн ойг тохиолдуулан мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлж, Атрын I, II, III аянд манлайлан оролцож, Монгол улсын хөгжил цэцэглэлт, хүн амыг эрүүл, аюулгүй баталгаат хүнсээр хангах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Мандал сумыг “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд олон жил үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан Дамбадаржаагийн Довдондэмбэрэлийг “Байгаль орчны гавьяат ажилтан” цолоор, нутгийн захиргаа, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан аймгийн Боловсрол соёл урлагийн газрын дарга Чойжамцын Жаргалсайхан, Сүхбаатар сумын ахмад настан, ахмад багш

Лувсангийн Буянт нарыг Монгол улсын Гавьяат багш цолоор, газар тариалангийн салбарыг хөгжүүлэх, Атрын II аяны зорилтыг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэж, газар тариалангийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Сүхбаатар сумын ахмад настан Ишдоржийн Нямбууг Монгол улсын Гавьяат эдийн засагч цолоор, биеийн тамир спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан, Үлэмж дархан мэргэн Дагвадоржийн Пүрэвийг Монгол улсын Гавьяат тамирчин цолоор, Халх голын байлдаанд оролцож эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалахад амь биеэ үл хайрлан тэмцэж баатарлаг гавьяа байгуулсан Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын уугуул Дагвадоржийн Шагдарыг Монгол улсын баатар цолоор нэхэн шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав.

Эрхэлсэн салбартаа амжилт гаргасан зарим иргэдийг төрийн одон медалиар шагнуулахаар уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 3, Алтан гадас одонгоор 23, Хөдөлмөрийн хүндэт медалиар 16 хүнийг шагнуулахаар уламжлав.

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Аймгийн ургацын комисс ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, заавар зөвлөмж өгөх, борлуулалтад анхаарах, сум орон нутгийн удирдлагуудад чиглэл өгөх зорилгоор 10 дугаар сарын 14-өөс 21-ний өдрүүдэд сумдад ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 10 дугаар сарын 1-ний байдлаар төмс 2455 га талбайгаас 116 цн буюу 33480 тонн хураан авч 99 хувьтай, хүнсний ногоо 2320 га талбайгаас 124 цн буюу 28720 тонн хураан авч 95 хувьтай, улаан буудай 108492 га талбайгаас нэгж 1 га-аас 11,8 цн буюу 127943 тонныг хураан авч 84,8 хувьтай байна.

Сэлэнгэ нутгийн үржил шимт хөрсөнд ургасан, шинэ ургацын экологийн цэвэр бүтээгдэхүүний “Сэлэнгэ ургац-2019” үзэсгэлэн худалдааг 10-р сарын 18-ны өдөр аймгийн төвд зохион байгуулж, 17 сумын 117 аж ахуйн нэгж, иргэд 70 гаруй нэр төрлийн төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, зөгийн бал, даршилж савласан ногоо, эмийн ургамал, гарурлал, ноос ноолууран эдлэл, гутал зэрэг бүтээгдэхүүнээр оролцож, 23,2 сая төгрөгийн борлуулалт хийсэн дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд малчдын түвшинд 142.1 мянган тонн байгалийн хадлан, 37.9 мянган тонн үйлдвэрийн тэжээл бэлтгэхээс байгалийн хадлан 144.25 мянган тонн, ногоон тэжээл 11627 тонн, бэлтгэсэн нь малчдын хэрэгцээт өвсний 101.6 хувь, тэжээлийг 75.9 хувийг бэлтгэсэн дүнтэй байна. 2019 оны 10 дугаар сарын 24-ний байдлаар аймгийн аюулгүйн нөөцөд 30 тонн тэжээл, 100 тонн өвс, сумдын аюулгүйн нөөцөд 900 тонн өвс, 250 тонн тэжээл бэлтгэсэн нь аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 50 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд төв суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 07 тоот албан даалгаварыг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумдын халаалтын төвүүдийн үйл ажиллагаа жигдэрсэн хэвийн явагдаж байгаа бөгөөд нийт сумдын халаалтын төвүүд дунджаар 10-15 хоногийн түлшний нөөцтэй байна. Нүүрсний гэрээг хийж, нүүрс таталтын ажлууд явагдаж байна.

Хот суурин газрын Цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга инженерийн шугам сүлжээний засварын ажил дуусч өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдсан, “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-аас Арангатын даваан дээр 8 хүний бүрэлдэхүүнтэй 3 төрлийн машин механизмтай шуурхай хэсэг байрлуулж, бэлэн байдлыг хангасан. Өвлийн онцгой нөхцөлд зам даваан дээр хэрэглэх хуурай дайрга шороо 300 м3, давс, цас хайлуулах бодис зэргийг нөөцлөөд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах тухай” 2007 оны 97-р зарлиг, Засгийн газрын 2007 оны 190-р тогтоолын дагуу “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

зохион байгууллаа. Арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад болон иргэний нийгмийн байгууллагууд, цахилгаан, ус, дулааны үйлчилгээ үзүүлэгч орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компани гэх мэт 44 байгууллага оролцож, давхардсан тоогоор 6200 гаруй иргэдэд нэг дороос үйлчилгээгээ үзүүллээ. Энэ арга хэмжээтэй хамтатган Авлигатай тэмцэх газрын “Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг”-ийг 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалтыг сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын ЗДТГ-ын дарга, аймгийн ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн холбогдох мэргэжилтнүүд, эрх бүхий албан тушаалтнууд нийт 110 албан тушаалтанд, “Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдэвт иргэдтэй хийх уулзалтыг “Сэлэнгийн долгио” чуулгын байранд зохион байгуулж, иргэдэд шинэ мэдлэг мэдээлэл олгох чиглэлээр танилцуулга мэдээлэл хийж, аймгийн Нийтийн номын санд “Авлигатай тэмцэх гарын авлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” зэрэг гарын авлагыг хүлээлгэн өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны маш нууц мн/135 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2019 оны н/93 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайд Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/302 дугаар захирамжаар 2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 2019 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс 14-ний өдрүүдэд Мандал, Сайхан, Сүхбаатар сумдад бүсчлэн зохион байгуулж явуулсан. Цэрэг татлагаар орох иргэдийн нэрийн жагсаалтыг гаргуулан авч цэргийн бүртгэлийн программтай тулган шалгаж зарлан дуудах мэдэгдлийг сумдын Засаг даргын Тамгын газраар дамжуулан хүргүүлж ажилласан. Хугацаат цэргийн албаны татлагаар эрүүл мэндээр тэнцэгчдийг хугацаат цэргийн албанд татаж Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагад хүлээлгэн өгч хяналтын тоог 100 хувь биелүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын ажил үйлчилгээний талаар

2019 оны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг аймгийн хэмжээнд нийт 17 сумд 6 тосгонд хийж, төлөвлөгөөний гүйцэтгэл 98 хувьтай байна.

Тайлант сард сумдын ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөр, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, хүүхдийн байгууллага, нийтийн эзэмшлийн талбайд байрлах тоглоомын аюулгүй байдал урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж шалгалтад нийт 33 ААН-ийг хамруулж 36 зөрчлийг илрүүлэн, газар дээр нь 28 зөрчлийг арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор улсын байцаагчдын хамтарсан 16 заалттай 4 албан шаардлагыг хугацаатай өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Дулааны станц, төвлөрсөн халаалтын зуухны өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, осол аваараас урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 4 зөвлөмж, 6 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Мөн Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын аюулгүй, найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай түлш тоног, төхөөрөмж, сэлбэгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зорилгоор улсын байцаагчийн 10 заалттай 1 зөвлөмжийг халаалтын зуухны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 7 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд Барилгын угсралтын ажил хийж байгаа болон нийгмийн салбарт ашиглагдаж буй барилга байгууламжийн өвөлжилтийн бэлтгэл байдалд хяналт шалгалт хийж хоногийн дундаж температур +5 хэмээс доош орох үед цутгамал бетон, өрөгт бүтээц, заслын ажлыг хэрхэн гүйцэтгэх талаархи зөвлөмжийг барилга угсралт засварын ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн

хяналт тавин ажиллаж байна.Зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын ажил гүйцэтгэсэн 1 аж ахуйн нэгжид хялбаршуулсан журмаар 1 зөрчлийн хэргийг нээж 5.000.00 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ тооцон ажиллалаа.

Стандартчлал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар

Тайлант сард тус хэлтсээс Хүдэр сумын Засаг даргын Тамгын газартай хамтран сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч 20 гаруй иргэн, аж ахуй нэгж, байгууллагад “Стандартчлал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”, “Хэмжил зүйн тухай хууль”, “Жижиглэн худалдааны газар түүний үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5021-1:2019” стандартын талаар мэдээлэл хийж, сумын ЗДТГ, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн багуудтай хамтран гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг зохион байгууллаа.

Бүтээгдэхүүн баталгаажуулалтын чиглэлээр Ерөө, Зүүнбүрэн, Хүдэр, Жавхлант, Баянгол, Сүхбаатар сумын нийт 18 аж ахуйн нэгж, иргэний 18 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 3 минимаркет, 14 хүнсний дэлгүүр, 1 махны мухлаг, 1 караоке баарны үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. Мөн Сүхбаатар сумын “Байгаль транс” ХХК-ий ирүүлсэн 7 нэрийн 12 төрлийн бүтээгдэхүүн, “Сэлэнгэ” талхан цехийн 1 нэрийн 2 талх, Сайхан сумын “Ган зоо тур” ХХК-ий үйлдвэрлэсэн “Толбот арзаахай” нэрийн цайг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид сорил шинжилгээнд хамруулж баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлтийг гаргаж өглөө.

Стандартын салбар сангаас 24 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 12 нэрийн 38 стандартын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, 9 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 12 нэрийн 19 стандартын борлуулалт хийж, Эзлэхүүн хэмжлийн төрлөөр Мандал, Баянгол сумдын “Дашваанжил” ХХК-ий 2 АХЦС-ын 4 түгээгүүр, Сүхбаатар, Хүдэр, Ерөө сум, Бугант, Дулаанхан тосгоны 10 шатахуун түгээх станцын 36 шингэн хэмжигчийг баталгаажуулж, 2 эмийн сангийн хэмжээт саванд шалгалт тохируулга хийсэн.

Механик хэмжлийн төрлөөр Хүдэр, Ерөө, Сүхбаатар суманд ажиллаж буй худалдааны газрын 83 жинг шалган баталгаажуулж, массын хэмжлийн төрлөөр “Спирт бал бурам” ХХК-ий чанар, хяналт сорилтын лабораторийн 10 элементрон жин, 18 ширхэг туухайд шалгалт тохижуулга хийж, цахилгаан хэмжлийн төрлөөр Сүхбаатар сум дахь “ДСЦТС” ХК-ий лабораторитой хамтран 1 фазын 403 цахилгааны тоолуурыг баталгаажуулалтад хамруулсан. Мөн аймгийн Биеийн тамир, спортын газрын усан бассейны 3 ширхэг термометр, “Гацуурт” ХХК-ий 4 ширхэг техникийн манометрт ээлжит баталгаажуулалт хийлээ.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн сард 15390 баримтаар 66.6 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэж, аймгийн төсвийн гүйцэтгэлийн 09 сарын нэгдсэн мэдээг гаргаснаас гадна мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажилдаж байна.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	1. Орон нутгийн төсвийн нийт орлого	59.156.299.8	56.821.938.7	96.1
	Орон нутгийн төсвийн орлого	15.837.708.2	14.940.638.8	94.3
1.1	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	12.007.780.5	10.841.799.4	90.3
	Сумдын төсвийн орлого	3.829.927.7	4.098.839.4	107.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	3.648.428.7	3.648.428.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	33.652.967.5	33.652.967.5	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох	4.367.140.8	3.966.371.0	90.8

	шилжүүлэг			
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/			
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	156.370.6	149.204.8	95.4
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/	1.361.858.1	332.501.9	24.4
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		71.725.440.7	62.388.515.7	87.0
Орон нутгийн төсвийн нийт зарлага		71.725.440.7	62.388.515.7	87.0
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		51.393.345.6	44.889.660.1	87.3
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		1.892.607.3	1.146.671.9	60.6
Сумдын сум хөгжүүлэх сан		1.062.609.4	265.932.0	25.0
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		19.675.739.5	16.870.130.3	85.7
Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		600.000.0	383.340.3	63.9
Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт		549.000.0	116.034.3	21.1
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан		1.980.551.8	1.510.654.8	76.3
Халамжийн сан		343.890.0	253.085.0	73.6
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		16.228.387.7	14.389.646.6	88.7
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		317.800.0	217.369.2	68.4
Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		37.263.389.9	34.139.227.9	91.6
Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		656.355.6	628.725.3	95.8
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		43.281.785.6	43.281.785.6	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	9.522.811.6	9.522.811.6	100.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		2.064.081.1	2.064.081.1	100.0
Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд		106.006.5	106.006.5	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд				
Хөрөнгө оруулалтын зардалд		1.958.074.6	1.958.074.6	100.0
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		2.321.702.4	1.902.289.9	81.9
Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд		1.980.551.8	1.558.317.0	78.7
Усны татаас		21.650.6	21.650.6	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		319.500.0	319.500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	33.045.267.4	33.045.267.4	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	607.700.1	607.700.1	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/		33.652.967.5	33.652.967.5	100.0
- Ерөнхий боловсролын сургууль		18.162.875.8	18.162.875.8	100.0
- Хүүхдийн цэцэрлэг		9.733.047.5	9.733.047.5	100.0
- Эрүүл мэндийн байгууллага		5.054.446.5	5.054.446.5	100.0
- Газрын кадастрын байгууллага		349.420.6	349.420.6	100.0
- Хүүхдийн байгууллага		353.177.1	353.177.1	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.361.858.1	332.501.9	24.4

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 09- сар	2019 09- сар	2019- 09 2018-09 Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			

1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 100	1 200	109.1
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	5 500	7 800	141.8
	Үхрийн мах /кг/	6 500	8 500	130.8
	Адууны мах /кг/	5 800	7 000	120.7
	Ямааны мах /кг/	5500	7 000	127.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	3000	4 000	133.3
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	900	1 000	111.1
	Сүү / савласан, л/	2 600	2 700	103.8
	Тараг /задгай, л/	1 200	1 300	108.3
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	15 000	115.4
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	800	1 000	125.0
	Лууван /кг/	1000	1 100	110.0
	Манжин /кг/	1000	1500	150.0
	Байцаа /кг/	1000	1200	120.0
	Сонгино /кг/	1200	1500	125.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 800	121.7
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 750	106.4
	Бензин А - 92	1 795	1 840	102.5
	Дизелийн түлш	2 105	2 370	112.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2019 оны 3 дугаар улирлын байдлаар иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн 2542 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 917 буюу 36 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1625 буюу 63,9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Эхний 9 сард 386 холбогдогчтой 1860.6 сая төгрөгийн хохиролтой, 590 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 10 хэргээр буюу 1.7 хувиар өссөн, гэмт хэргийн илрүүлэлт 48.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн, нийт 21016 зөрчлийг илрүүлсэн нь 3908 зөрчлөөр буюу 22.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 10 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 166, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 34-ийг бичиж үйлчилсэн.

Тайлант сард иргэний бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэл 306, гэрлэлтийн бүртгэл 108, гэрлэлт цуцалсны бүртгэл 14, үрчлэлт 9, эцэг тогтоолт 97,

овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 9, нас баралт 85, иргэний үнэмлэх олголт 441 хийгдэж, гадаад паспорт олголт 94, ОХУ-ын хавсралт 3073-ыг олгож, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 110, хот доторх шилжилт хөдөлгөөн 214 тус тус бүртгэгдсэн байна.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэгийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад сургалт зохион байгуулж, архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи онолын болон дадлагын хичээлийг заасан.

Төрийн архивыг нөхөн бүрдүүлэх 2019 оны төлөвлөгөөний дагуу хөмрөг үүсгэгч 7 байгууллагад албан бичиг хүргүүлж, Шаамар сумын Засаг даргын Тамгын газрын 1990-2011 оны 72 хадгаламжийн нэгжийг шилжүүлэн авч, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн архив, бичиг хэргийн эрхлэгч нарт баримтаа шилжүүлэх үүрэг чиглэл өглөө. Мөн шинээр ашиглалтанд орсон болон их засварын ажил хийгдсэн барилга, байгууламжийн баримт бичиг хүлээн авах ажлын хүрээнд Шаамар сумын төрийн байгууллагуудын инженерийн шугам сүлжээний засварын ажил, Цагааннуур сумын Ахмадын байрны барилгын засварын ажил, Сүхбаатар сумын “Хөх чулуут” төвийн урд талбайн зам засварын ажил, Алтанбулаг чөлөөт бүс дэх дэлгүүрийн барилга, Хушаат сумын төвөөс Орхон голын гүүр хүртэлх 6 км хайрган хучилттай зам, Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн төрөх эмнэлэг, яаралтай тусламжийн хэсгийн барилга, Зүүнбүрэн сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, Сүхбаатар суманд баригдсан “Горгаз” ХХК-ийн автомашин хийгээр цэнэглэх станцын барилгын баримтуудыг байнгын хадгалалтанд шилжүүлэн авлаа.

Нийтийн ахуйн үйлчилгээний удирдах газар, Зэлтэр, Орхон САА, аймгийн Шүдэнзний үйлдвэрийн хөмрөгийн 15 хадгаламжийн нэгжийн 1878 хуудас баримтын мэдээллийн агуулгыг уншиж заалт 1511, хүний нэр 7756, байгууллагын нэр 575, газар зүйн нэр 501 шивж, 26 хадгаламжийн нэгжийн 2903 хуудас баримтыг эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэж, Зэлтэрийн САА-н хөмрөгийн 10 хадгаламжийн нэгжийн 864 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэн цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Энэ сард байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу архивын хуулбар цахимаар 110, цаасан суурьтай баримтаас 30, мастер хувиас 13, цалингийн тодорхойлолт 1, магадлагаа, тодорхойлолт нийт 32 тус тус гаргаж үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

2019 оны 10 дугаар сарын 03-ны өдөр “Дэлхийн багш нарын 25, Монголын багш нарын 53, соёлын ажилтны өдөр”-ийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, Монгол Улсын Засгийн газрын болон БСШУСЯам, аймгийн ИТХ, Засаг дарга, БСУГ-ын шагналаар зарим багш ажилтнуудыг шагнасан. Баярын арга хэмжээнд зориулан “Амжилт, шийдэл, шинэчлэл” сэтгүүлийг гарган сургууль цэцэрлэгүүдэд хүргүүлэн ажиллалаа.

БСШУСЯ, БҮТ-өөс 10 дугаар сарын 03-ны өдөр “Цахим хурал”-ыг зохион байгуулж, 2018-2019 оны хичээлийн жилд сургалтын чанар, үр дүнд дүгнэлт хийх, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ хийх зорилгоор авч байгаа чанарын үнэлгээний судалгаат шалгалтыг зохион байгуулж, улсын дунджид хүргэж ажиллахыг анхааруулсан.

2019 оны 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт зохион байгуулсан Хангайн бүсийн сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйч нарын “Багшид үзүүлэх мэргэжил арга зүйн дэмжлэг, манлайлал” сэдэвт сургалтад ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйч, мэргэжилтэн нийт 92 хүноролцож, сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлэх арга зүйн дэмжлэг,

сургалтын хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалтын менежерийн манлайллын чиглэлүүдээр суралцаж, арга зүйгээ дээшлүүлсэн.

Хөдөөгийн багш нарын спортын XVII наадам 2019 оны 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод зохион байгуулагдаж Дорнод, Дундговь, Дорноговь, Орхон, Хөвсгөл, Архангай, Хэнтий, Сэлэнгэ, Өмнөговь, Говь-Алтай, Завхан аймгийн 500 гаруй тамирчин багш нар оролцож тэмцээн сагсан бөмбөг, волейбол, шатар, теннис, шагайн харваа гэсэн 5 төрлөөр зохион байгуулагдсан. Тэмцээний сагсан бөмбөгийн төрөлд Сэлэнгэ аймгийн эмэгтэй баг мөнгөн медаль, волейболын төрөлд эрэгтэй баг алтан медаль, эмэгтэй баг алтан медаль, шатрын төрөлд эрэгтэй мөнгөн медаль, теннисний төрөлд эмэгтэй алтан медаль, шагайн харвааны төрөлд мөнгөн медаль хүртэж нийлбэр дүнгээр Сэлэнгэ аймгийн баг тэргүүн байр шилжин явах цом, хүртсэн.

“Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Багшлахуй хичээл ажиглалтын аргачлалыг танилцуулах” болон “Бага ангийн сурагчдын унших чадварыг үнэлэх, хөгжүүлэх арга зүй”-н туршилтын үр дүнг таниулах сургалтад холбогдох мэргэжилтэн хамрагдаж, сургалтыг орон нутгийн бага боловсролын 310 багш, сургалтын менежерүүдийг хамруулан зохион байгуулсан.

БНСУ-ын Жинжү Боловсролын Их сургууль, МУБИС-ийн Багшийн сургуультай хамтран бага ангийн багш нарт “Математик, Байгалийн ухаан”-ы хичээлийн арга зүйн сургалт зохион байгуулсан.

“Суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээллийн технологийг оновчтой ашиглах” төслийн хүрээнд аймгийн багш нарын бэлтгэсэн сургалтын цахим хэрэглэгдэхүүн DVD-г туршин хэлэлцэх “Туршилт хэлэлцүүлэг” сургалтыг зохион байгуулж хэлэлцүүлэгт аймгийн нийт 33 ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежерийн төлөөлөл бүхий 50 багш оролцож сургалтын 6 цахим хэрэглэгдэхүүний эхний хувилбартай танилцан, хэлэлцүүлсэн.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн үзэл санаа баримтлал, зарчим, зорилго зорилт, агуулга, арга зүй, үнэлгээний арга зүйг таниулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулж сургалтад 1-12-р ангид Иргэний ёс зүйн боловсролын хичээлийн 66 багшийг хамруулсан.

2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 34 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 42 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж буй нийт 76 нэгж байгууллагын статистик мэдээг “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ээр нэгтгэж БСШУСЯ-нд хүргүүлсэн.

Энэ хичээлийн жилд 42 цэцэрлэгт 7880 хүүхэд хамрагдан 652 удирдах ажилтан, үндсэн болон туслах багш ажиллаж, 34 сургуульд 20338 суралцагч суралцаж, 1209 багш, удирдах ажилтан ажиллаж байна.

Соёлын ажилтны өдөр болон Дэлхийн багш нарын баяраар Засгийн газрын шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр-1, Биеийн тамир Спортын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр-3, Соёлын тэргүүний ажилтан-6, Тэргүүний ардын авьяастнаар-1, БСШУС-ын Яамны шагнал “Хүндэт жуух бичиг”-ээр 19, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Хүндэт тэмдэг”-ээр 1, “Хүндэт өргөмжлөл”-өөр -9, аймгийн Засаг даргын жуух бичгээр 13 багш удирдах ажилтан, “Арга зүйч” тэмдгээр-66, “Ахлах багш” тэмдгээр -55, “Багшийн алдар” тэмдгээр-40, “Шилдэг багш” тэмдгээр-8, “Шилдэг менежер” тэмдгээр-3, “Бүтээлч багш” тэмдгээр-8, “Ахмадын алдар” тэмдгээр-17, “Боловсролын төлөө” тэмдгээр-20, “Бүтээлч соёлын ажилтан” тэмдгээр-1, “Шилдэг уран бүтээлч” тэмдгээр-6, “Шилдэг номын санч” тэмдгээр-1, “Бүтээлч ардын авьяастан” тэмдгээр-4 багш ажилтнуудыг шагнаж урамшуулсан.

Аймгийн соёлын төв, соёлын ордон, мэргэжлийн урлагийн байгууллагын дарга, эрхлэгч, хөгжим, бүжгийн багш, уран бүтээлчид, ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш нарын мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтыг Соёл, урлагийн их сургуультай хамтран зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын ивээл дор Ахмадын баярыг угтан “Дуун цэнгүүн” арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд 7 сумын 8 багийн 900 гаруй ахмадууд оролцлоо.

Мастерсийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд Хангарьд, БГД, Виста, БЗД, ОБЕГ, Орчлон, Дархан СПА, Сэлэм загас, 33-р сургууль, Тэмүүлэл, Jarden, АПУ трейд, болон Сэлэнгэ аймгийн ОБГ, Усан спорт сургалтын төвийн нийт 40 гаруй тамирчид 5 насны ангилалд, өвөрөөр даллах сэлэлт /50 метр/, араар даллах сэлэлт /50 метр/, мэлхий сэлэлт /50 метр/, далайн гахай сэлэлт /50 метр/ зайд хурд хүчээ сорин өрсөлдсөн.

2.Эрүүл мэндийн чиглэлээр

“Сэлэнгэ аймагт бөөр орлуулах эмчилгээг нэвтрүүлсний 5 жилийн ойд зориулсан сургалт”-ыг Нэгдсэн эмнэлгүүд болон сум тосгоны эрүүл мэндийн төвийн их эмч, сувилагч нарын 60 хүнд зохион байгуулсан.

2019 онд цагааннуур бүсэд гарсан амьгүй төрөлт хүүхдийн эндэгдлийн эмнэлзүй эмгэг судлалын хурлыг зохион байгуулж хуралд эрүүл мэндийн газрын удирдлага, мэргэжилтнүүд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын сум дундынэмнэлэг, Цагааннуур, ерөө бүсийн Эрүүл мэндийн төвийн дарга эх баригч нарын 43 хүн оролцсон. Ерөнхий боловсролын 1,6-р сургуулийн нийт 400 гаруй сурагчдад “Эрүүл амьдралын хэв маяг”, “Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт”-ийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх арга замын талаар сургалт зохион байгуулсан.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 09-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 707 байсан бол 301иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 207 ажлын байранд 187 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 179 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 642 болсон.

Орон нутгийн төсвийн орлогоос:

2019 оны эхний 10 сарын байдлаар халамжийн санд орон нутгийн төсвөөс 262175,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тайлант хугацаанд 423 иргэнд 117570.0 мянган төгрөгийг олгосон. Үүнд:

-Онцгой тохиолдлын тэтгэмжид 47 иргэнд 56400,0 мянган төгрөг

-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 376 иргэнд 61170,0 мянган төгрөг

Улсын төсвийн орлогоос:

Халамжийн санд улсын төсвөөс 13,975,661,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тайлант хугацаанд 40284 иргэнд 11044807,7 мянган төгрөгийг олгосон.

Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2556 иргэнд 3590491,8 мянган төгрөг

-Нийгмийн халамжийн тэтгэмжид 1741 иргэнд 991704,9 мянган төгрөг

-Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1641 иргэнд 633521.3 мянган төгрөг

-Жирэмсэн эхийн тэтгэмжид 2527 эхэд 315321,1 мянган төгрөг

-Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8787 эхийн 1149600,0 мянган төгрөг

-Цалинтай ээж хөтөлбөрт 6222 эхэд 2199317,4 мянган төгрөг

-Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжинд 222 иргэнд 186298,7 мянган төгрөг

-Насны хишгийн тэтгэмжид 4775 ахмадад 719150,0 мянган төгрөг

-Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 5147 ахмадын 439737,5 мянган төгрөг

-Алдар цолтон ахмад настанд 71 ахмадын 61564,9 мянган төгрөг

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 551 иргэний 136031,9 мянган төгрөг

-Хүнсний эрхийн бичгийн 5875 иргэнд 609978,6 мянган төгрөг
-Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулалд 169 иргэнд 12089,6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 9 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал:

-Бие махбодын хүчирхийлэл-3

- Сэтгэл санаа- 6 байна.

“Хүндэтгэлийн танхим”-аар 1 залуу хосын гэрлэлтийн батламжийг гардуулж, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар зөвлөмж, үйлчилгээ үзүүлсэн.

Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад сурталчлан таниулах, тэдний дунд уран уншлагыг хөгжүүлэх зорилгоор “Уран жиргээ ” аймгийн наадмыг 4 насны ангиллаар зохион байгуулж нийт 13 сумын 65 хүүхэд хамрагдсан. Тэмцээний сургуулийн өмнөх насны ангилалд Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн Б.Энхнаран, бага насны ангилалд Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн сурагч А.Амарзаяа, Дунд насны ангилалд Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагч Ө.Хулан, ахлах насанд Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагч Э.Энхсүлд нар шалгарсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 60 дугаар зарлиг, 2019 оныг “Хүүхэд хамгааллын жил”, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Орхонтуул сумдад зохион байгуулсан. Үүнд:

-Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хурлыг зохион байгуулан ажлын тайланг сонсож, арга зүйгээр ханган ажилласан.

-Хүүхдийн эрхийн зөрчилтэй 3 гомдол мэдээллийг Зөрчлийн тухай хуулийн 6.20.13, 6.20.15-д зааснаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэв.

-Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг 173 хүүхдэд үзүүлж, ганцаарчилсан зөвлөгөөг 26 насанд хүрэгч, 6 хүүхдэд, бүлгийн зөвлөгөөг 159 сурагчдад өглөө.

-Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 107 хүүхдийн гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, эрсдлийн программд бүртгэж авсан.

-Гэр бүлийн туршилтын хөтөлбөрт хамрагдсан 68 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 41 хүүхдийн өрх гэр бүлд дэмжлэг үзүүлсэн.

-Аймгийн Хүүхдийн VIII чуулганыг зохион байгуулж, 200 хүүхэд хамрагдаж, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт 47 санал, санаачилгыг хүргүүлж, Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнд хүүхдийн төлөөллийг сонгосноор, хүүхдийн дуу хоолойг шийдвэр гаргах түвшний хүмүүст хүргэх төлөөлөлтэй болсон.

-Цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд “Үлгэрч аав” арга хэмжээг зохион байгуулж нийт 37 эцэг эх, 70 хүүхэд хамрагдсан.

“Халамжтай аав” арга хэмжээг залуу аавуудын дунд зохион байгуулж 25 аав оролцож, 589 өрхөд сурталчлан таниулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн хөвгүүд, охидод “Дэлгэцийн донтолт-Хорт зуршил” сэдэвт лекц уншиж, нийт 325 сурагч, “Бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нь” арга хэмжээнд 300 хүүхэд хамрагдсан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2019 оны 10 дугаар сарын байдлаар 28,9 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 10 дугаар сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 30,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 106,4 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16814 тэтгэвэр авагчдад 52761156 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 5889 хүнд 2352121 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 274 хүнд 882079 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 440 хүнд 598996 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал 10 сард 5 удаа хуралдаж, 271 хүнээс 13 хүний группийг цуцалж, 39 хүнийг шинээр тогтоож, 179 хүн актаа сунгуулсан байна. Мөн нүүдлийн ЭХМК-ын 1 хурлаар нийт 315 хүнээс 293 хүнийг сунгаж, 22 хүнийг цуцалсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2019 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт Нийгмийн даатгалын салбарын ажилтан, албан хаагчдыг чадавхижуулах бүсийн сургалт зохион байгуулсан бөгөөд уг сургалтад Нийгмийн даатгалын хэлтсийн 35 ажилтан, албан хаагчид оролцсон.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, сумдын хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагаанд мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх “Зөвлөн туслах” ажлын хэсэг Мандал, Баянгол суманд ажиллалалаа. Ажлын хэсгээс ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажилтай газар дээр нь танилцан холбогдох зөвлөгөө дэмжлэгийг үзүүлээ.

“Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний шинэчилсэн стандарт, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал сургалт, ур чадварын тэмцээн, урлаг, спортын наадмыг ХХААХҮЯ-тай хамтран 10 дугаар сарын 4-нөөс 6-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Төв, Сэлэнгэ аймгийн 150 гаруй тогооч, зөөгчдийн төлөөлөл оролцож, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нэвтэрсэн олон улсын хөгжлийн чиг хандлага, туршлага, арга технологи, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалтын горим, ширээ засалт, чимэглэл, шинэ техник, технологи, зочдод үйлчлэх үйлчилгээ, үйлчилгээний соёл, төрөл, онцлогууд, ажлын байрны зохион байгуулалт, дулааны боловсруулалтын арга ажиллагаа технологи, хүүхдийн хоол гэсэн төрлүүдээр танхимийн болон дадлага ажлын сургалт хийгдэж, ажил мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн, урлаг, спортын арга хэмжээг тус тус зохион байгуулсан.

Органик хүнс, үйлдвэрлэгчдийн чуулганыг 4 дэх жилдээ зохион байгуулагдсан чуулганд тус аймгаас 23 хоршооны 31 иргэн хамрагдсан бөгөөд “АДРА Монгол” ОУБ-ын “Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл”-д хамрагдсан аймгийн 2 тариаланч тангараг өргөлөө.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/133 дугаар тушаал, 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр цехийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын 02 тоот нэгдсэн удирдамжийн дагуу аймгийн “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТТҮГ-ын мал нядалгааны цехийн үйл ажиллагаа болон Сүхбаатар сумын махны мухлаг, худалдааны төвүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тус тус хийлээ. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгснөөс гадна “Гацуурт” ХХК-ий махны үйлдвэр, “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын мал нядалгааны цехээс 7 хоног бүр мэдээг авч нэгтгэн МЭЕГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Улсын онцгой комиссын хуралдаанаас гарсан шийдвэр, МЭЕГ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу махны нөөц бүрдүүлэх талаар Шаамар, Цагааннуур, Алтанбулаг сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт мэдээлэл өгч, 6 сумын 120 малчин, мал бүхий иргэдэд мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад дүрэм журмын талаар заавар зөвлөмж, ухуулга яриа таниулга хийлээ.

Аймгийн хэмжээнд 10 дугаар сард зах зээлд худалдан борлуулагдсан адуу 353, үхэр 1240, хонь 2612, ямаа 592, гахай тахиа 5, нийт 4804 толгой мал амьтан, адууны мах 4280 кг, үхрийн мах 51600 кг, тэмээний мах 1240 кг, Хонины мах 7739 кг, ямааны мах 1350 кг, гахай тахийны мах 1585 кг, нийт 67,8 тн мах, махан бүтээгдэхүүн, 9710 л сүүн бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгож баталгаажуулсан.

Тайлант сард 12 сумаас 12 аймагт отроор 6683, арилжаагаар 2245, уралдаан тэмцээнд 43 бүгд 8971 толгой мал өөр аймаг суманд шилжин явж аймгийн хэмжээнд нийт 10260 толгой мал шилжилт хөдөлгөөн хийсэнд гэрчилгээ олгож баталгаажуулалт хийж хяналт тавин мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Аймгийн хэмжээнд сумдын Мал эмнэлэг үржлийн 45 нэгжээс мал амьтны эрүүл мэндийн үзлэгийг хийж, адуу 95239, үхэр 201214, тэмээ 480, хонь 691629, ямаа 512983 нийт 1,5 сая толгой мал хамрагдлаа.

Мөн ийлдэс судлалын шинжилгээнд Шаамар, Цагааннуур, Орхон, Зүүнбүрэн сумдын 51 хуц, 49 ухна, нийт 100 мал, амьтанд бруцеллёз шинжилгээг хийж хариуг олгож ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ явуулах тухай" А/154 тоот захирамжаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд МУЗГ-ын 225-р тогтоолын 1-р хавсралт дахь улсаас санхүүжүүлэх тарилганд 564.0 мянган толгой мал, амьтан, 2-р хавсралт дахь орон нутгаас санхүүжүүлэх тарилганд 262.0 мянган толгой мал, амьтан, 3-р хавсралт дахь иргэд, ААН-ээс төлбөр авах тарилганд 353.0 мянган толгой мал, амьтан буюу нийт 1179.0 мянган толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд 9-р сарын байдлаар улсаас санхүүжүүлэх тарилганд 561.5 мянган толгой мал, амьтан, орон нутгаас санхүүжүүлэх тарилганд 271.0 мянган толгой мал, амьтан, иргэд, аж ахуйн нэгжээс төлбөр авах тарилганд 352.5 мянган толгой мал, амьтан буюу технологит хугацаанд давхардсан тоогоор нийт 1184.0 толгой мал, амьтан буюу 100.4%-ийг хамруулаад байна. "Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, сорил шинжилгээ зохион байгуулах тухай" захирамжаар нийт 565.8 мянган толгой төл мал хамруулахаас технологит хугацаанд одоогийн байдлаар 51.9 мянган толгой тугал, 422.7 мянган толгой хурга, ишиг буюу нийт 544.7 мянган толгой төл малыг 96.3 хувьтай хамрагдсан байна.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

2019 оны төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулах ажлыг 100 хувь цахимаар зохион байгуулсан. Сум, агентлагийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д оруулахад хяналт тавин ажиллаж байна.

Тайлант сард ндсэн хөрөнгө актлаж, данснаас хасахаар нийт 11 байгууллагын 168 ширхэг тодорхой нэр төрлийн 803,1 сая төгрөгийн хөрөнгө, үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдахаар 5 байгууллагын 7 ширхэг 81,6 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэхээр 11 байгууллагын 26 ширхэг 498,2 сая төгрөгийн хөрөнгө, барилга байгууламж, газрын хамт дуудлагын худалдаагаар худалдахаар 1 байгууллагын 71,1 сая төгрөгийн хөрөнгийг тус тус аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлээ.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 19 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулж, Сүхбаатар сумын 45 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн үйлчилсэн. Банк болон банк санхүүгийн байгууллагад газар эзэмх эрхийн гэрчилгээгээ барьцаалан зээл авч байгаа 14 иргэн аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн барьцааны

бүртгэлийг газрын цахим биржид бүртгэлжүүлэн 12 иргэн аж ахуйн нэгжийн барьцааг чөлөөлж газрын мэдээлийн санд холбон ажилласан.

2019 онд аймгийн хэмжээнд “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажил”-ын хүрээнд нийт 96 мониторингийн цэгийг байгуулан хээрийн хэмжилтийн боловсруулалтыг “Ланд менежер” програмд оруулан тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын А/270 тоот захирамжийн дагуу 10 дугаар сарын 08-аас 10-ны өдрүүдэд Ерөө сумын Бугант тосгоны “Агуйт” гэх газарт зөвшөөрөлгүй бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байсан Эскэватор /3ш/, Машин /2ш/, Помп /1ш/, тус тус албадан буулгаж, Бугант тосгоны захирагчийн албанд хүлээлгэн өгсөн. Мөн зөвшөөрөлгүй газар ашиглаж шинээр кареар гаргаж байсан “Мондет” ХХК-ий үйл ажиллагааг зогсоож, тоног төхөөрөмж техникийг лацдаж, битүүмжиллээ.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

Сумдын тариалангийн талбайд хөрс хөлдөх үеийн судалгааг хийж байна. Уринштай талбайн 0-20 см гүн дэх чийгшлийн нөөц Баянгол, Баруунбүрэн, Сант сумдын нутгаар хангалтгүй, Мандал, Орхон, Алтанбулаг, Хушаат, Сайхан, Түшиг, Цагааннуур сумдад дунд, бусад сумдын нутгаар хангалттай хэмжээнд байна. 0-50, 0-100 см гүнд Баянгол, Баруунбүрэн, Сант сумдын нутагт хангалтгүй, Мандал, Хушаат, Сайхан, Цагааннуур сумдын нутагт дунд, бусад сумдын нутагт хангалттай хэмжээнд байна. Гуурстай талбайн 0-20 см гүнд Баянгол, Орхон, Мандал, Цагааннуур, Баруунбүрэн Сайхан, Түшиг, Хушаат сумдад хангалтгүй, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдад дунд, Ерөө суманд хангалттай хэмжээнд, 0-50 см гүнд Баянгол, Баруунбүрэн Мандал, Цагааннуур, Сайхан сумдад хангалтгүй, Орхон, Алтанбулаг, Сант, Зүүнбүрэн, Түшиг, Хушаат сумдад дунд, бусад сумдын нутагт хангалттай, 0-100 см гүнд Баруунбүрэн, Баянгол, Хушаат, Сайхан сумдад хангалтгүй, Түшиг, Алтанбулаг, Сант, Орхон, Мандал, Цагааннуур сумдад дунд, бусад сумдын нутагт хангалттай гэсэн үнэлгээтэй байна

Уул уурхайн ашигт малтмал явуулаад нөхөн сэргээсэн талбайн хэмжээг дрон ашиглан хийж, 3D зураг боловсруулах аргаар хэмжих ажлыг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харицаа, барилга хот байгуулалтын газрууд хамтран зохион байгууллаа. Арга хэмжээнд Ерөө суманд бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 34 нөхөрлөлийн талбайд хийж, 114,8 га талбайг тэгшилсэн байсныг хэмжиж тогтоогоод байна.

Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдтэй биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд Сант сумын “Баян баавгайт”, Алтанбулаг сумын “Баянчацаргана”, Баруунбүрэн сумын “Байгалийн хишиг” зэрэг нөхөрлөлүүдэд мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн.

Хүдэр, Мандал, Ерөө сум, Бугант тосгонд ажиллаж ойн менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн явцтай танилцаж, 22 нөхөрлөлийн 2018-2019 онд хийсэн ажлын тайланг үзэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн мод бэлтгэлийн талбай тусгаарлахад шаардлагтай гэрээ, акт бусад баримт бичгийг шалган ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл 11, аж ахуйн нэгж байгууллага 15 мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Хөв цөөрөм байгуулах ажлыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалтын ажлыг Орон нутгийн өмчийн газартай хамтран зохион байгуулж “Вэлмот” ХХК шалгаран гүйцэтгэл 70 хувьтай байна.

Аймаг орон нутаг, байгалийн үзэсгэлэнт газар, түүх дурсгалын газруудыг сурталчилах гадаад дотоодын жуулчдыг татах зорилгоор аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран Орхон, Баруунбүрэн, Сант, Хушаат, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Сүхбаатар, Алтанбулаг, Ерөө, Жавхлант, Мандал зэрэг сумдын нутгийг хамруулан тойрон аяллыг зохион байгуулан уг аялалд 18 хүн оролцлоо.

Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Зүүнбүрэн сум:

Тайлант сард Улаанбаатар хотын “Иргэдийн хэрэглээний боловсролын төв”-тэй хамтран сумын 43 албан хаагчийг хамруулан эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтыг, аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжлийн газартай хамтран байгууллагуудын эцэг эхийн зөвлөл, хамтарсан багийн гишүүдэд зориулан хүүхэд хамгааллын сургалтыг зохион байгуулсан.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 1 үрчлэлт 1, гэрлэлт 3, нас баралт 1, иргэний үнэмлэх олголтын 12, биеийн давхацахгүй өгөгдлийн бүртгэл 8 баг доторх шилжилт хөдөлгөөн 2 тус тус бүргэж нийт 34 бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүллээ.

Монголын багш нарын баярыг тохиолдуулан “Бид багш” арга хэмжээг зохион байгуулж, амжилттай ажилласан багш нарыг шагнаж урамшууллаа.

Олон Улсын Эко сургуулийн хөтөлбөрийг Хүрэл гэрэгэ гардан авч, ахисан түвшний I шатны сургалтад сургуулийн захирал, 2 багшийн хамт хамрагдаж, аймгийн Гэр бүл Хүүхэд Залуучууд Хөгжлийн газраас зохион байгуулсан хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд “Хөгжилд хүүхдийн оролцоо” чуулган, охидын сургалтыг тус тус зохион байгууллаа. Мөн “Алтан намар” арга хэмжээг зохион байгуулж, 25 багш, 510 сурагч, 250 гаруй эцэг эх хамрагдлаа.

Сумын цэцэрлэгийн хамран сургалт 10 дугаар сарын хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 23 хоног 3956 хүүхэд өдөр хамруулахаас 3106 хүүхэд өдөр хамруулж, өдрийн төлөвлөгөөний биелэлт 78,5 хувь, 24 цагийн ажиллагаатай бүлгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 19 хоног 570 хүүхэд хоног хамруулахаас 464 хүүхэд хоног хамруулж, 81,4 хувьтай байна.

Эрүүл мэндийн төвөөс тайлант сард амбулатороор 286 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 125, урьдчилан сэргийлэх үзлэгээр 97, дисдансерийн хяналтаар 39, гэрийн идэвхтэй эргэлтээр 10, дуудлагаар 15 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлж, 24 иргэнийг хэвтүүлэн эмчилж, ээлжит товлолт вакцины хамрагдалт 1 хүртэлх насны хүүхдийг 100 хувь, сахуу татрангийн вакцинд 7 болон 15 настай 64 хүүхдийг тус тус хамрууллаа. Эхний 10 сарын байдлаар эхийн эндэгдэлгүй ажиллаж байна.

2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу өвөлжөө хаваржааны зориулалтаар 17 иргэнд 13,26 га, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамалын зориулалтаар давуу эрхээр 18 иргэнд 47,5 га газрыг тус тус эзэмшүүлж, өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшигч 3 иргэний хүсэлтийн дагуу 2,34 га газрын эзэмших эрхийг шилжүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 тоот зарлиг, аймгийн Засаг даргын 2019 оны А/309 тоот захирамжийн хүрээнд намрын мод тарилтын ажлыг зохион байгуулж 70200 төгрөгийн зардлаар 245 ширхэг жим жимсгэний мод тариалж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалаар 120 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн өргөтгөлийг суурь цутгалтын ажил эхэлж, орон нутгийн хөгжлийн сангийн 13,5 сая төгрөгийн хөрөнгөөр 1 дүгээр цэцэрлэгт гүний худаг гаргах ажил хийгдэж байна.

Баруунбүрэн сум:

Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн баярын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний дагуу “Атарчдын уянга дуу”-ны уралдаан, “Атар-60” жилийн ойн дурсгалын хөшөө, самбарын загварын уралдааны удирдамжийг боловсруулан олон нийтэд сурталчлан ажиллаж байна. Мөн ойн арга хэмжээний хүрээнд хийгдэж буй баримтат кинонд орох тариаланчдын зургийг авлаа. Аймгийн төвд зохион байгуулагдсан “Сэлэнгэ ургац-2019” үзэсгэлэн худалдаанд сүү сүүн бүтээгдэхүүнээр 2 иргэн, ногоочин 1-ийг хамруулсан. Уг арга хэмжээний сүү сүүн

бүтээгдэхүүн хийдэг Н.Бундтулгат органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгч номинацид шалгарч, сайн зохион байгуулж оролцуулсан албан тушаалтнаар шалгарсан.

Төмс, хүнсний ногооны ургац хураалтын ажил дуусч, үр тарианы ургац хураалтын явц 10-р сарын 25-ны байдлаар сумын дүнгээр 68 хувьтай байна.

Баруунбүрэн сумын Бургалтай 2 дугаар багийн Далтын өвөрт отроор ирсэн Ц.Сономпилийн суурьт халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг тандалт, угаалга, туулгалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг цаг тухай бүрт зохион байгуулсны үр дүнд халдварт өвчин гараагүй учир сумын Засаг даргын А/89 тоот захирамжаар хорио цээрийн дэглэмийг цуцалсан. Сумын мал эмнэлгийн үржлийн эмч нар хамтран 2 суурийн 152 ухна, 218 хуц, нийт 370 толгой хээлтүүлэгчид эрүүл мэндийн үзлэг хийсэн.

Орхон бүсийн сум дундын ойн анги цөлжсөн, элсний нүүлтэнд өртсөн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын хүрээнд Баруунбүрэн сумын 5 га талбайд агч, хайлаас модоор ойжуулалтыг хийсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын ногооны талбайг хашаажуулах ажлыг сумын ногоочдын бүлгээр гүйцэтгүүлэн ашиглалтанд оруулж, сумын төв талбайд хөшөө босгох, усан оргилуурыг ашиглалтанд оруулах ажлыг иргэдийн бүлгээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 09-р сарын 19-ны өдрийн 1/702 албан тоотыг үндэслэн “Ахмад настан-Хэрэглэгч” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд ахмадуудын өөрсдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүн, оёдол хатгамал, сүү сүүн бүтээгдэхүүн, ногооны үзэсгэлэнг гаргуулан иргэдэд үзүүлж худалдаа хийлгэсэн. Үзэсгэлэнд Ивэнгийн 1-р багийн малчин өндөр настан С.Чанцалын базмал ааруул, хайлмаг тосоор хийсэн бүтээгдэхүүн 1-р байр, Цагаан-овооны 3-р багийн ногоочин Д.Явайгийн дарсан ногооны дармал бүтээгдэхүүн 2-р байр, Бургалтайн 2-р багийн малчин Д.Мягмарсүрэнгийн хийсэн арвайн гурилтай өрөм 3-р байр эзэлсэн. Мөн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, ахмад настны тухай хуулийн талаарх мэдээллийг ахмадуудад өгч харилцан ярилцлаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандартын дагуу зохион байгуулж, Сумын Ахмадын хороо, спорт цогцолбортой хамтран ахмадын баярын үеэр настангуудын бие бялдарыг чийрэгжүүлэх, сэтгэл санааг тайван, эв нэгдлийг бий болгох зорилгоор спортын уралдаан тэмцээн /хөгжилтэй буухиа, теннис, дардас шидэлт/ зохион байгууллаа. “Томуу, томуу төст өвчин”-өөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, нийт 60 хүүхдийг хамруулсан. Мөн сумын 1-р цэцэрлэгийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, “Цэвэр гар эрүүл мэнд” сэдэвт гар угаах арга болон бохир гараар үүсгэгдэх өвчний талаар сургалтыг нийт 109 хүүхдэд зохион байгууллаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас нийт 162 хүүхэд хамрагдахаас нийт 140 гаруй хүүхэд хамрагдаж 86%-тай ажиллаж байна.

Шаамар сум:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Сэлэнгийн Ургац-2019” үзэсгэлэн худалдаанд сумын төмс, хүнсний ногоо, зөгийн аж ахуй өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг оролцуулах ажлыг орон нутагт зохион байгуулж, иргэдэд мэдээ мэдээллийг цахим орчин болон мэдээллийн самбар үүрэн холбоогоор мэдээлж, нутгийн үржил шимт хөрсөнд тарьж ургуулсан шинэ ургацын бүтээгдэхүүнээр “Сэлэнгэ ургац-2019” үзэсгэлэн худалдаанд тус сумын 1 аж ахуйн нэгж, 8 иргэн 20 гаруй нэр төрлийн төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү цагаан идээдаршилж савласан ногоо, зөгийн бал, зөгийн бүтээгдэхүүнээр оролцож, 1937000 төгрөгийн борлуулалт хийж, нутгийн ард иргэд, үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийнхээ бараа бүтээгдэхүүнийг худалдан авч үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж оролцсон сайхан арга хэмжээ болж өнгөрлөө.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Атрын-60 жил”-ийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Аваргуудаараа гайхуулцгаая” арга

хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Одонгоо зүүцгээ” бахархалын уулзалт, үдэшлэгт Шаамар сумаас төрөн гарсан үе үеийн Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Гавъяат механикжуулагч, Улсын аварга хадланчид, Улсын хварга тариаланчид зэрэг 19 аваргыг оролцууллаа.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт судалгааг хийж 15 өрхийн 150 толгой үхэрт “Адууны ям, сүрьеэ, лейкоз өвчний тандалтыг хийж цус авч лабораторын шинжилгээнд явуулж, “Махны нөөц бүрдүүлэх тухай” Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 10-р дугаар сарын 01-ны өдрийн 01/1046 тоот албан бичиг “Мах бэлтгэлийн талаар өгөх зөвлөмж”, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 10-р дугаар сарын 17-ны 1/767 тоот албан бичгийг малчин мал бүхий иргэдэд танилцуулж, Засаг даргын захирамжийг боловсруулан батлуулж, махны нөөц бүрдүүлэлтийн талаар малчид болон, мал бүхий иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2009-2016 онуудад Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамнаас Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан малчид тариаланчдад олгосон бага оврын тракторын зээлийн хугацаа хэтэрсэн зээлдэгчдийг шүүхэд шилжүүлэх болсонтой холбогдуулан тус сумын харъяат малчдад мэдээлэл хүргэлээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Ойн тухай хууль, Амьтны тухай хууль бусад холбогдох дүрэм журам болон Мэргэжилийн хяналтын газрын даргын 18-04-003/02 тоот байнгын удирдамжийн хүрээнд Байгаль хамгаалагч, хэсгийн цагдаа нар хяналт шалгалт хийж, Манжийн тохой гэх газарт эзэн холбогдогчгүй 2 метрийн урттай 100 ширхэг нойтон бургас бэлтгэсэн байсныг журмын хашаанд буулгасан.

Тужийн нарс, Царам зэрэг газруудад хүрэн баавгай харагдах болсон учир тус орчинд амьдардаг болон хадлан тэжээл бэлтгэж байгаа иргэдэд өндөр сонор сэрэмжтэй байхыг сануулж сумын Тамгын газрын цахим хуудсаар нийтэд мэдээлж байна.

Сумын хэмжээнд “Хоггүй цэвэрхэн Монгол” аяныг 10 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулж, 9 аж ахуйн нэгж байгууллагын 176 ажилтан албан хаагч оролцож, сумын төв дундуур нэвтрэн өнгөрөх төв зам, бүүрэг толгой, төмөр замын нүхэн гүүр орчим болон бусад нийтийн эзэмшил талбайгаас нийт 17 портер хогийг түүж цэвэрлэн төв хогийн цэгт буулгалаа.

Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ"-ний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 12 өрхийн 89 гишүүнд 2019 оны 10 дугаар сарын талон болох 129 ширхэг үнэт цаас бүхий 1032000 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ийн "Шонхлоу" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

Мандал сум:

Төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг сумын төв болон Тарни 8-р баг, Хэрх, Түнхэл тосгонд зохион байгууллаа. Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын байцаагч суманд ирж ажиллан бичиг баримтаа хаясан, үрэгдүүлсэн 180 иргэний материалыг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэснээс гадна Төрийн үйлчилгээний 10 чиглэлээр иргэдэд үйлчилгээ үзүүлснээс гадна суманд үйл ажиллагаа явуулдаг хууль хүчний болон боловсрол эрүүл мэндийн чиглэлийн 32 байгууллага оролцон нийт давхардсан тоогоор 1218 иргэнд үйлчилгээ үзүүллээ. Өдөрлөгийн үеэр модны тарьц суулгац, өрхийн болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар урлалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдлаа.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 3 удаа хуралдаж хорих ангиас суллагдсан гэр оронгүй 2 иргэнд тус бүр онцгой тохиолдлын 1 удаагийн буцалтгүй тусламж 1,2 сая төгрөг олгохоор, харж хандах үр хүүхэдгүй ганц бие

өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг асрамжийн үйлчилгээнд явуулахаар, тэжээн тэтгэх үр хүүхэдгүй ганц бие ахмад настанд түлшний хөнгөлөлт 4, хүндэт донор ахмад настны түлшний хөнгөлөлт 4, нийт 11 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн.

Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ахмад настны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2 удаа зохион байгуулж нийт 44 ахмадыг хамрууллаа.

Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан баярын үйл ажиллагаа, уулзалт зөвлөгөөнийг Мөнгөн Хараа дуу бүжгийн чуулгад зохион байгуулж 200 гаруй ахмадыг хамрууллаа.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газраас зохион байгуулсан Малчдын туршлага солилцох уулзалтыг Мандал суманд 2019 оны 10 сарын 22-ны өдөр зохион байгуулан ажилласан. Уг уулзалтад Сэлэнгэ аймгийн 17 сумаас зочид төлөөлөгчид оролцсон бөгөөд Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн газрын дарга, Хөдөлмөрийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Сумдын Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлэнд хамрагдсан малчид бүхий 60 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалтыг 10-р сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 136 иргэнийг хамруулсан.

Хотын төвийн дотор 3-р багт Политехник коллежийн уулзвараас Баянсуудал-2 гудамж хүртэл 1880 м, Засаг даргын тамгын газраас Нүхэн гарц хүртэл 1020 м нийт 2,9 км хатуу хучилттай замыг барьж ашиглалтанд оруулсан.

Улаанбаатар–Дархан чиглэлийн /А0401/ авто замын 130 км-ээс Мандал сум хүртэлх хуримтлуулах 28,9 км авто замын далангийн ажлын гүйцэтгэл 100 хувьтай, 51 ширхэг гүүр хоолой барих ажлын гүйцэтгэл 100 хувьтай, цементээр бэхжүүлсэн суурь 6,8 км хийгдэж 23 хувьтай, суурь асфальтан хучилтын ажил 6,8 км хийгдэж 23 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус замын ажил хүйтний улирлын улмаас зогссон бөгөөд авто замын хөдөлгөөнийг 10-р сарын 18-ны өдрөөс нээгээд байна.

Түнхэл тосгонд Түнхэл голын эрэг дагуу газар өмчилж авсан гэр хорооллын 40 айл өрхийг үер усны аюул, эрсдлээс эмзэг байдлыг бууруулах зорилгоор “Дэлхийн зөн Зүүнхараа” ОНХХ, “Бороо Гоулд” ХХК-тай хамтран 800 м үерийн даланг байгуулсан.

Мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг 11 нөхөрлөл, 11 аж ахуйн нэгж, 1 иргэнд 744 м³ хэрэглээний, 921 м³ түлээний, нийт 1665 м³ мод бэлтгэх зөвшөөрлийг, 5 нөхөрлөл, 16 аж ахуйн нэгж, байгууллагын 1416м³ хэрэглээний, 219 м³ түлээний, нийт 1635 м³ мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 тоот зарлиг, 2013 оны 178 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2019 оны 10 -р сарын 01-ээс 13-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгууллаа. Бүх нийтээр мод тарих ажилд нийт 54 өрх, 32 төр, төсвийн аж ахуй нэгж, байгууллагын 384 хүн идэвхитэй оролцож 54 өрх 242 ширхэг, нийтийн эзэмшлийн талбай болон байгууллагын тохижилтонд 497 ширхэг буюу нийт 739 ширхэг мод, бут сөөг тарьж бүгд идэвхи санаачлагатай оролцсон. Шинээр 60 м газрын хайсжуулан мод тарилтыг хийсэн.

Баянгол сум

Хүн ам, орон сууцны тооллогыг 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгууллаа. Тооллогоор сумын хэмжээнд сууцны тусдаа байшин 984, бие даасан сууц 6, сууцны бус зориулалттай 103, гэр 470, нийтийн зориулалттай орон сууцны байшин 15, нийт 1578 ширхэг байшин орон сууц тоологдсон.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн баталсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх

ажлын хүрээнд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Ахмад настан-хэрэглэгч” аяныг энэ сард зохион байгуулсан.

Сумын Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/201 тоот Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах тухай захирамжийн дагуу 4 аж ахуйн нэгж байгууллагын 58 ажилтан, албан хаагчид нарс, агч, буйлс, үрэл, хайлаас, шар хуайс, бургас зэрэг 7 нэр төрлийн 353 ширхэг мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ.

Атрын 60 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн баатар Ч.Баяраагийн дүрийг мөнхлөх зорилгоор түүний баримлыг сумын Засаг даргын Тамгын газрын цэцэрлэгт талбайд байгуулахаар үр хүүхдүүд нь санаачлан хийж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. Мөн Баянгол сумын “Атар-60, Түүхэн замнал” баримтат кино, нэвтрүүлгийг бэлтгүүлж байна. Үүний хүрээнд Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарынхны улс эх орны хөгжил дэвшилд оруулж буй хувь нэмрийг олон нийтэд таниулан сурталчилах, ахмад, тариаланчид, ногоочид, нутгийн ахмадуудын ажил хөдөлмөрийн замнал, түүхэн алдрыг мөнхжүүлэх, мөн хүнс хөдөө аж ахуйн салбарт залуучуудын идэвх санаачлагыг өрнүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Алтан намар-2019” танин мэдэхүйн реалити нэвтрүүлгийг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээний хаалтын үйл ажиллагаанд авьяаслаг оюутан, залуучуудын урлагийн тоглолтыг хийж, 150 хүн хамрагдлаа.

Аймгийн төвд зохион байгуулагдсан “Аваргуудаараа бахархъя” уулзалтад тус сумаас төрсөн 7 аварга оролцлоо.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын "Хараагийн баян үрс" хоршооны зөгийн бал нь "Намрын ногоон өдрүүд" нэгдсэн арга хэмжээний "Эрүүл монгол хүнс-2019" үзэсгэлэн худалдааны "Шилдэг органик бүтээгдэхүүн"-ээр шалгарсан байна. Мөн аймгийн төвд болсон “Сэлэнгийн ургац-2019” үзэсгэлэн худалдаанд тус сумаас төмс, хүнсний ногооны төрлөөр Хараа багийн иргэн Б.Уранцэцэг, М.Долгормаа, сүү, цагаан идээ, цай үйлдвэрлэлээр Гонир багийн иргэн Д.Хишигмаа нар оролцож, Д.Хишигмаагийн хушгатай цай, цайны цуглуулга нь "Шинэ нэр төрлийн шилдэг бүтээгдэхүүн"-ээр шалгарч аймгийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

МЭХ-ны Сэлэнгэ аймгийн салбар зөвлөл, сумын салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулсан “Өөдлөн дэвжих цаг” эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгууллаа. Чуулганы хүрээнд Соёлын төвийн ажилчын урлагийн тоглолт, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа явуулж арга хэмжээнд 350 эмэгтэйчүүд хамрагдсан байна.

Дэлхийн багш нарын 25, Монголын багш нарын 53 дахь өдрийг тохиолдуулан багш нарын баярын хурал, “Багшийн ёс зүйн тангараг” өргөх ёслолын үйл ажиллагаа, 12а,б ангийн сурагчид “Багш дор мөргөмүй” урлагийн тоглолтыг зохион байгуулж, зарим багш, ажилтнуудыг шагнаж урамшуулсан.

2019.10.16-17-ны өдрүүдэд ОУ-ын Эко сургууль хөтөлбөрийн 5-р чуулган болж, БОАЯЖ, БСШУСЯ, Нийслэлийн цагдаагийн газрын Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, ОХУ-ын Эко сургууль хөтөлбөрийн баг болон нийт 13 аймаг, нийслэлийн 80 гаруй ЕБС, цэцэрлэг, коллежийн удирдлага хамт олон оролцлоо. Хоёр дахь Ногоон тугийг Улсын хэмжээнд 6 сургууль, аймгийн хэмжээнд 2 сургууль авсан ба тус чуулганд сургуулийн захирал Д.Сарангэрэл багш, ажилчдын төлөөллийн хамт оролцож Алтан гэрэгэ, 2 дахь “Ногоон туг”-аа хүлээн авлаа.

“Багш-сурагч солилцоо” хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Улсын тэргүүний сургуулийн англи хэлний багш, химийн багш, бага боловсролын багшнар мөн тус сургуулийн 3 сурагчид хүрэлцэн ирж, манай сургуулийн химийн багш П.Бат-Эрдэнэ, англи хэлний багш О.Ганцэцэг, бага боловсролын багш Б.Алтаннавч, 12а ангийн сурагч Д.Жаргал, 11б ангийн сурагч А.Мэндсайхан, 10б ангийн сурагч Б.Амаржаргал нар хамтран ажиллаж, харилцан бие биенээсээ суралцлаа.

2019-2020 оны хичээлийн жилийн сургуулийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулагдаж, 18 багийн 144 тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцлоо.

Сумын цэцэрлэгийн түүхт 50 жилийн ойг угтаж Хараа бүсийн цэцэрлэгүүдийн хүүхдийн дунд “Өсөх ирээдүйтэй бөх”-ийн тэмцээнийг зохион байгууллаа. Мөн цэцэрлэгийн анги танхимыг тохижуулах зорилгоор эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж байна. Үүнд:

-Тоглоомын талбайн орчныг СӨББ-ын стандартын дагуу тохижуулж аюулгүй тохилог орчныг бүрдүүлсэн

-Хүүхдийг номтой нөхөрлүүлэх ном унших шилдэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх зорилгоор номын өргөөг сайжруулан шинэчлэн тохижуулсан.

-Цэцэрлэгийн гадна фасадын ажлыг сумын удирдлагуудын тусламж дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэлээ.

- “Хүндэтгэлийн булан” төслийг хийж хэрэгжүүлж, ахмад багш ажилчид асар майхан хийж цэцэрлэгтээ бэлэг барилаа.

Ойн баярын арга хэмжээг 2019 ны 10 дугаар сарын 15-ны билэгт сайн өдөр 50 жилийн түүхт ойгоо тэмдэглэн өнгөрүүлээ. Хүүхэд багачуудад монгол ахуй, зан заншил, уламжлалыг таниулах зорилготой хийгдсэн “Ёс заншлын өргөө”-ний нээлтийг хийж зочид төлөөлөгчиддөө танилцууллаа. БСШУСЯ-ны сайд Ё.Баатарбилэг болон аймгийн засаг дарга Ш.Оргил нар цэцэрлэгийн түүхт ойд мэндчилгээ илгээж, хурлын үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Энхбат, БСУГ-ын дарга Ч.Жаргалсайхан нар хүрэлцэн ирж мэндчилгээ дэвшүүлж багш ажилчдыг шагнаж урамшууллаа.

Сумын Эрүүл мэндийн төв амбулаториор нийт 511 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 29 иргэнийг онош тодруулахаар илгээсэн. Хүлээн авах хэсгээр 296 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн.Стационарт 36 хүнийг хэвтүүлэн 720,0 мян/төгрөгийн эм тариа, ороох боох материал зарцуулан, эмчилсэн.Түргэн тусламжийн нийт 48 дуудлага хүлээн авснаас алын 16, осол гэмтлийн 2 дуудлаганд явж үйлчилсэн.

Сумын ЭМТ-ийн барилга 1968 онд анх баригдаж ашиглалтанд орсон. Анхан шатны эмнэлгийн үйл ажиллагаа явуулах өрөө тасалгааны хүртээмж муутай байдаг. Иймд сумын нутаг дэвсгэрт явуулдаг уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Тод Ундарга ХХК-д сумын удирдлагуудын зүгээс тус байгууллагатай нийгмийн хариуцлагын гэрээгээр Эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөлийн хэсгийг бариулах санал тавьснаар яаралтай тусламжийн нэгжийн өртгөтгөлийн шинэ барилга баригдаж, аймгийн мэргэжлийн хяналтын газарт хянуулан, өргөтгөлийн барилгыг хүлээн авснаар иргэдэд ая тухтай орчинд, яаралтай тусламж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үзүүлэх ээлтэй орчин бүрдээд байна.

2019 оны 10 сарын байдлаар артерийн гипертензи, чихрийн шижин өвчний илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 1462 иргэнийг 100 хувь хамруулсан.

Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт энэ сард 51 иргэн, хөх умайн хавдар эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 10 эмэгтэй тус тус хамрагдсан байна.Нэг цэгийн үйлчилгээгээр 7 иргэн үйлчлүүлж, өвчлөл илрээгүй байна.Тэмбүүгийн урьдчилсан сорил шинжилгээнд 26 иргэн хамрагдснаас 3 эерэг тохиолдол илэрсэн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч Пентатерра ХХК нь 4,2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Ойн тухайн хуулийн холбогдох заалтын дагуу түлээ бэлтгэх эрхийн бичгийг 11 иргэнд 88 м3 бэлтгэхээр олгож 225,500 төгрөгийг, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийн бичиг 2 аж ахуйн нэгж, байгууллагад 700 тонн голын хайрга ашиглах эрхийн бичиг олгож нийт 1,750,00 төгрөгийг, 2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолд Баянгол суманд бор гөрөөс-2 ширхэг, зэрлэг гахай -1 ширхэг, загас -100 ширхэг барихаар

тус тус тогтоосон. Тогтоолын дагуу 1 ширхэг зэрлэг гахайн агнах эрхийн бичгийг олгож 140,000 төгрөгийг төрийн санд тус тус төвлөрүүлсэн.

“Ариун шимт байгаль” ТББ нь аймгийн БОАЖГ-ын Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлэн хийгдэж байгаа Хараа багийн Бор толгой гэх газарт ногоон зурвас байгуулахаар 5 га газрын хашаажуулан улиас, хайлаас зэрэг 2 нэр төрлийн 3000 мод тарьж ногоон зурвас байгуулаад байна.

2018 оны жилийн эцсийн мал тооллогоор 421 малчин, 364 мал бүхий иргэн, 4 ААНБ-ын 138797 толгой мал тоологдож хонин толгойд шилжүүлснээр 262223 толгой мал өвөлжихөөр малчид, мал бүхий иргэд маань өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангаж дууссан. Сумын хэмжээнд 7250 тонн байгалийн хадлан, 1560 тонн сүрэл, 579 тонн ногоон тэжээл, 6 тонн гар тэжээл бэлтгэн авсан.

Үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулах аймгийн МЭГ-ын МАЭМА-ны даргаар ахлуулсан ажлын хэсэг 10 дугаар сарын 6-ны өдрөөс 9-ний өдөр хүртэл ажилласан ба суманд ажиллах 4 МЭҮН-ийн хариуцсан өрхүүдээс сонгон 20 өрхийн 200 үхэр хамруулсан болно.

2019 онд 20 аж ахуй нэгж, 12 иргэн 5765 га талбайд улаан буудай, 70 га талбайд овъёос, 351 га талбайд гурвалжин будаа, 2104 га талбайд рапс, 362 га талбайд ногоон тэжээл тарьсан. 10 сарын 22-ны өдрийн байдлаар улаанбуудай 3470 га талбайг ангилан хурааж 4230 тн ургац, шуудаар 1029 га талбайгаас 842 тн ургац аваад байна. Улаан буудайн ургац хураалт 100 хувьтай, нэг га талбайгаас дунджаар 11 цн ургац хураан авч байна. Овьёос, тэжээлийн ургамлын хураалт 100 хувь дууссан. Рапс нийт 2104 га тариалснаас 713 га талбайгаас 139 тонн рапс хурааж аваад байна. Төмс, хүнсний ногооны хураалт 100 хувь дуусч, зоорьлолтын ажил хийгдэж байна. Энэ жил 102 га-д төмс тариалж 1000 тонн төмс, хүнсний ногоо 88,31 га тариалж 730 тонн ургац хураан авсан.

Сайхан сүм

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах, байгууллагынхаа нийт ажилтан, албан хаагчдын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Хамт олны хариуцлагыг нэмэгдүүлэх сарын аян”-ыг сумын Засаг даргын Тамгын газрын нийт ажилтан, албан хаагчдын дунд 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдрөөс эхлүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 296-р тогтоол, “Эрдэнэс-Таван толгой” ХК-ий 1072 хувьцааны өөрчлөлттэй холбоотойгоор гарсан алдаа зөрчлийн залруулах зорилгоор Улсын хэмжээнд хийгдэж буй “Хуримтлалтай хувьцаатай иргэн аян”-ы хүрээнд иргэдэд мэдээлэл өгөх арга хэмжээг 2019 оны 10-р сарын 13, 14-ний өдрүүдэд сумын Соёлын ордонд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр сумын хэмжээнд 1072 хувьцааны данс нээлгээгүй иргэдэд данс нээх, 1072 хувьцаагаа хэрхэн ашиглах талаар зөвөлгөө өгч ажиллав.

Сайхан сумын төр төсөв, хувийн хэвшлийн байгууллагууд, үйлдвэр аж ахуйн газруудын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, бүх төрлийн үйлчилгээг нэр дороос иргэдэд шуурхай хүргэх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилго бүхий “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2019 оны 10-р сарын 23-ны 10:00-17:00 цагт Хөтөл соёлын ордонд зохион байгуулан ажиллаа. Тус нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийт 31 төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн тусгай болон хувийн аж ахуй нэгж байгууллага оролцсон бөгөөд давхардсан тоогоор 350 гаруй иргэн үйлчлүүлж санал гомдлоо илэрхийлэн үйлчилгээ авсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 06-р сарын 26-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор Сайхан сумын Гавшгай 2-р багийг хуваан шинээр Дөмбөн 4-р багийг байгуулсан.

Сайхан сумын хэмжээнд Хүн ам, орон сууцны тооллогын сумын комисс байгуулагдан 9-р сарын 24-өөс 10-р сарын 8-ныг хүртэл байшин, орон сууцны тооллогыг зохион байгуулж дуусгалаа. Сумын хэмжээнд сууцны тусдаа байшин

685, бие даасан тохилог сууц 10, нийтийн байр 6, сууцны бус зориулалттай 101, гэр 574, нийт 1406 байшин, орон сууц, нийтийн байр, сууцны бус зориулалтын байр, гэр, нийтийн зориулалттай байр тоологдлоо.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуугэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 10 дугаар сард 2 удаагийн захирамжаар 98 иргэн, нийт 81413.2 м² газрыг үнэ төлбөргүй өмчилж авсан. Өмчлөлийн газраа бусдад шилжүүлсэн 15 иргэн, авто грашийн зориулалттай 4 нэгж талбар, өвөлжөөний зориулалттай 2 нэгж талбарийн нийт 6 иргэн газар эзэмших эрхээ бусдад шилжүүлж, 1 иргэний 2 нэгж талбарын газрыг сумын Засаг даргын захирамжаар гэрээ, гэрчилгээг цуцласан.

"ХОГГҮЙ ЦЭВЭР СЭЛЭНГЭ" аяны хүрээнд аймгийн БОАЖГ-аас Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар сургалт зохион байгуулсан бөгөөд, 24 иргэн хамрагдсан.

2019 оны 10-р сарын 5-нд сумын багш нарын баярын үйл ажиллагааг сумын нийт багш, ажилтнуудыг хамруулан зохион байгуулав. Үйл ажиллагааны үеэр төрийн одон медаль, салбарын шагнал, аймаг, сумын ИТХ, Засаг даргын шагналаар эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэлтэй, боловсролын салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж буй 40 гаруй багш, ажилтныг шагнаж урамшуулав.

Боловсролын орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах ажлын хүрээнд сумын хүүхэд хамгааллын хамтарсан багаас хүүхэд, багачууд, эцэг эх, багш нарт хандсан "Хүчирхийлэлгүй нийгэм" сургалтыг зохион байгуулж, 1200 гаруй хүүхэд багачууд, 260 эцэг эхийг хамруулан ажиллав. Сургалтын үеэр эцэг эхчүүдэд "Гараас гарт" зөвлөмжийг танилцуулан, цэцэрлэг болон болон бага ангийн хүүхдүүдийг багшаас хүлээн авч, хүлээлгэн өгөх талаар зөвлөмж өгч ажиллав.

Сайхан сумын Олон Улсын Ахмадын баярын арга хэмжээ нь сумын хэмжээнд 1,2-р багийн 494 ахмад настнаас 320 ахмадууд баярын үйл ажиллагаандаа идэвхитэй оролцлоо. Баярын үеэр ахмадуудын дунд хөгжөөнт тэмцээн, дуу болон бүжгийн тэмцээн зохион байгуулж шилдгүүдээ тодруулав.

Сант сум

Аймгийн "Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ" аяны хүрээнд 10 дугаар сарын 11-12-ний өдрүүдэд нийтийн хог цэвэрлэгээг сумын хэмжээнд зохион байгуулж, төр, төсвийн 5 байгууллага, 5 аж ахуйн нэгж, 2 багийн айл өрхүүд хамрагдаж 14м³ хогийг цэвэрлэж, тээвэрлэн хаясан.

Сумын Засаг даргын 2019 оны А/27 тоот захирамжаар хүн ам орон сууцны тооллогын сум багийн комисс 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж хүн ам, орон сууцны тооллогын ажлыг зохион байгууллаа. Сумын хэмжээнд нийт 604 сууц тоологдсоноос 321 байшин, 279 гэр, нийтийн зориулалттай сууц 5 тоологдсон дүнтэй байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ Сант суманд ажиллаж сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн, ГХУСАЗСЗ-ийн дарга нартай уулзаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. "Хөгжилд хүүхдийн оролцоо" аймгийн хүүхдийн 8 дугаар чуулганыг суманд зохион байгуулж, 40 хүүхдийг хамруулан, хүүхдийн дуу хоолойг сонсож чуулганаас гарсан 12 заалт бүхий уриалгыг сумын Засаг даргад гардуулж өглөө. Энэ үеэр мөн гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн өрхүүдэд зочлон, 1 дүгээр цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд "Халамжит аав, Үлгэрч аав ээж" тэмцээнийг зохион явууллаа.

Мандал суманд зохион байгуулагдсан "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт"-т хамрагдсан залуу малчдын туршлага солилцох уулзалт зөвөлгөөнд сумын 4 залуу малчин оролцсон.

Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, "Сэлэнгэ талст" ХХК хамтран "Ахмад настан хэрэглэгч" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай", "Ахмад настанд

хэрэглэгчийн боловсрол олгох" , "Улсын бүртгэлийн шинэчилсэн хуулийн заалт", "Ахмад настны хөдөлмөр эрхлэлт", "Тархины цус харвалт өвчний тухай", "Эмийн зохистой хэрэглээ", "Ахмад настны тэтгэврийн зээлийн талаар" холбогдох мэргэжилтнүүд мэдээлэл хийж "Ахмад настан хэрэглэгч" сэдвийн дор хэлэлцүүлэг зохион явууллаа. Мөн хийн дасгал болон 16 тоот бүжгийн тэмцээн, эрүүл мэндийн үзлэг, азын сугалаа зэрэг арга хэмжээнүүд явагдаж 25 ахмад настан хамрагдсан байна.

Сумын ИТХ-ын дарга, Засаг даргын нарын дэмжлэгээр "Ахмадын өдөр" хүндэтгэлийн арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлж 150 гаруй ахмад настан хамрагдсан. Энэ үеэр суманд үйл ажиллагаа явуулж буй 46 аж ахуйн нэгж байгууллагууд харьяаллын ахмад настанууддаа хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа. Ахмадын баярыг угтаж аймгийн аварга малчин Ивэн 1-р багийн иргэн Т.Баатаржав нийгмийн хариуцлагын хүрээнд 5 ахмад настан тус бүрд 1 хонь хандивласан байна. 2019 оны байдлаар сумын хэмжээнд 250 ахмад настан бүртгэлтэй байна.

Сэлэнгийн эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулж буй "Өөдлөн дэвжих цаг" чуулганы арга хэмжээ тус суманд зохион байгуулагдлаа. Чуулганд 200 гаруй эмэгтэйчүүд оролцсон.

Сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургууль, орон нутгийн түншлэлд тулгуурласан олон улсын "Эко сургууль" хөтөлбөрийн анхан шатны шаардлагыг бүрэн хангаж "Хүрэл гэрэгэ" гардан авсан байна.

Сүхбаатар сум

Улсын хэмжээнд зохион байгуулагдах байшин орон сууцны тооллогыг сумын хэмжээнд 09 дүгээр сарын 24- 10 дугаар сарын 12-ны өдрийг дуусталх хугацаанд сумын явуулж дууслаа. Сумын хэмжээнд нийт 5143 асуулгаар сууцны тусдаа байшин 4063, бие даасан тохилог сууц 207, нийтийн байр 84, сууцны бус зориулалттай байшин 464, гэр 195, нийтийн зориулалттай орон сууц 130 тоологдлоо.

Сумын ИТХ-ын ээлжит 2 дугаар хуралдаанаар сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2019 оны биелэлтийг хэлэлцүүлж, "Хангалттай" үнэлгээ авлаа. Мөн 2020 оны сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлууллаа.

БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны УХО бизнес холбоо нь тус сумын ЗДТГ-тай хамтран ажиллах чиглэлээр гэрээнд гарын үсэг зурсан. БНСУ-ын Чонсон мужийн нутгийн удирдлагын байгууллагын урилгаар сумын ИТХ, ЗДТГ-ын зарим албан хаагчид туршлага солилцлоо.

Сумын эмэгтэйчүүдийн зөвлөл, Сүхбаатар сумын ЗДТГ "Гэр бүл дэх эрчүүдийн оролцоо болон гэр бүлийн үнэ цэнэ" хэлэлцүүлгийг зохион байгуулж, 8 багийн 148 иргэн хамрагдлаа.

Сургууль цэцэрлэгийн 2019-2020 оны хамран сургалтын судалгааг шинэчлэн гаргалаа. Энэ хичээлийн жилд СӨБ-ын 7 байгууллагад 1996 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд хамран сургалт 95,9 хувьтай байна.

"Сэлэнгэ байк" клубын дугуйчид Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Чингис хаан-2019" Азийн унадаг дугуйн наадамд оролцож, багаараа 2-р байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн. Дээрх тамирчдын зардалд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 400000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Монгол Улсын Их хурлын гишүүн, 29 дэх Ерөнхий сайд Жаргалтулгын Эрдэнэбатын ивээл дор Сэлэнгэ аймгийн харьяат оюутан, залуучуудын дунд жил бүр зохион байгуулагддаг "Сэлэнгэ лиг-2019" спортын наадамд 140 багийн 1200 гаруй баг, тамирчид өрсөлдсөн бөгөөд тус сумаас оролцох баг, тамирчдыг бүрдүүлэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж, багийн нийлбэр дүнгээр "ДЭД" байрт шалгарлаа.

Мөн УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Н.Оюундарийн санаачилгаар 2 дахь жилдээ БНСУ-ын нүдний нарийн мэргэжлийн эмч нар

Сүхбаатар сумын 320 гаруй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд хараа зүйн үйлчилгээ үзүүлж, нүдний шил тааруулан өгч үйлчиллээ.

Биеийн тамир, спортын тухай хууль, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх, ахмадуудын дунд нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцох идэвхийг өрнүүлэх, нөхөрсөг баг, хамт олныг бүрдүүлэх зорилгоор ахмадын 5 төрөлт ширээний теннис, шатар, дардас, хөзөр, софт волейбол зэрэг тэмцээнийг 2019 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тэмцээнд 8 багийн давхардсан тоогоор нийт 120 гаруй ахмад оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, нийлбэр дүнгээр 1-р байрт Орхон 6-р баг, 2-р байрт Буурхээр 8-р баг, 3-р байр Боргүвээ 5-р багийн ахмадууд шалгарлаа.

Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, тэдний авъяас чадварыг хөгжүүлэх, ахмадуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, хамтран уран бүтээл туурвих, соёлын солилцоог хөгжүүлэх зорилгоор Бэлчир бүсийн ахмадуудын дунд “Насны намар” дуун цэнгүүнийг 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Дуун цэнгүүнд Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Дулаанхаан тосгоны нийт 150 гаруй ахмадууд оролцож, бүсийн ахмадуудын дунд гоцлол дуу /эрэгтэй, эмэгтэй/, нийтийн бүжгийн төрлөөр уралдаан зохиож, шилдгүүдээ тодруулан шагнаж урамшууллаа.

USAID байгууллагын санхүүжилтээр Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр Монголын багш-Эцэг эхийн холбоо, сонсголын бэрхшээлтэй иргэдтэй хамтран хэрэгжүүлж байгаа “Сонсголын бэрхшээлтэй сонгогч иргэн” төслийн хүрээнд зохион байгуулагдсан Сонсголын бэрхшээлтэй иргэдийг сонгуульд тэгш, үр дүнтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх, сонсголгүй иргэдэд дохионы хэлээр сонгогчийн боловсрол олгох сургалтанд тус сумын 52 иргэнийг хамрууллаа.

Хоггүй Сэлэнгэ аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж Албан байгууллага 35, Аж ахуйн нэгж 67, 472-н айл өрхийн 945 иргэн 275 албан хаагч нар хог цэвэрлэгээнд идэвх санаачлагтай оролцож 62тн хог хаягдлыг цэвэрлэж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр” зарлах тухай 63 дугаар зарлигийн дагуу намрын мод тарилтын өдрийг зохион байгуулж 8 дугаар багт 5 га газар ойн зурвас бий болгож 3000ш мод, ногоон паспорт аяны хүрээнд 3.5 га газар 500 ширхэг мод тарьж ажиллалаа.

“Сэлэнгийн ургац 2019” үзэсгэлэн худалдаанд тус сумаас аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэгч 18 иргэн төмс, хүнсний ногоо, даршилсан ногоо, сүүн цагаан идээ, зөгийн бал, ширэн эмээл, хазаар,суран эдлэл зэрэг бүтээгдэхүүнээр оролцлоо. Ган зам 7-р багийн иргэн Б.Ууганбаярын ширэн эмээл, хазаар, суран эдлэл “Олны таашаалд нийцсэн бүтээгдэхүүнээр” шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа. Үзэсгэлэн худалдаанд нийт 1.650.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Атар 60 уилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд сумдуудаар аялаж байгаа Атар- 60 туг, хүндэт дэвтрийг хүлээн авч ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Хушаат сүм:

Ахмадын баярын арга хэмжээний хүрээнд сумын Ахмадын хорооноос "Архигүй баяр-Аз жаргалтай инээмсэглэл" цэнгүүн, "Дуун цэнгүүн" "Бүжгийн тэмцээн", Г.Очиржанцан агсны нэрэмжит шатрын тэмцээнийг тус тус зохион байгуулсан.

Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойд зориулан Атарын 1,2-р аянд ажиллаж хөдөлмөрлөж явсан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн хошой одонт Д.Пүрвээ, Алтан гадас одонт Г.Очир нарын дурсамж яриаг гэрэл зургийн хамт сумын “Нээлттэй Хушаат” цахим хуудас, Fb хуудсанд нийтэлж олны хүртээл болголоо.

Мөн түүхт ойн хүрээнд зохион байгуулагдсан "Сэлэнгэ ургац-2019" шинэ ургацын хүнсний ногооны үзэсгэлэн худалдаанд Хушаат сумаас 4 ногоочин 17 төрлийн хүнсний ногоо, 11 төрлийн даршилсан ногоогоор оролцож 800.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Дэлхийн багш нарын 25, Монголын багш нарын 53 жилийн ой, багш нарын баярыг тэмдэглэн өнгөрүүлээ. Арга хэмжээгээр "Багшаа дагаж шавь нь хөгждөг" хишиг өдөр, "Биднээс цацрах аялгуу" концерт, "Багшдаа баярлалаа" үдшийн цэнгүүн, хүндэтгэлийн хурлыг зохион байгуулж, зарим багш нарыг шагнаж урамшууллаа.

Монгол Улсад охидын эрхийн өдрийг тохиолдуулан дунд ангийн охидод "Охидын шивнээ" сэдвээр анги удирдсан багш нар яриа хийж, үе тэнгийнхний найз нөхөрлөл, шохоорхол, өөртөө итгэлтэй байдал, охидын бие физиологи гарч байгаа өөрчлөлт, анхаарах асуудлуудын талаар ярилцаж ярилцлагад оролцсон охиддоо зөвлөгөө өгч, бага ангийн хөвгүүдийн санаачлагаар ангийн охиддоо "Охиндоо бичсэн шүлэг"-ийг уншиж, өөрсдийн гараар урласан цэцэг, зүрхэн наалт бэлэглэлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын А/340 тоот тушаалаар суралцагчийн халдварт болон халдварт бус өвчлөлөөс сэргийлэх зорилгоор хичээлийн жилд 2-оос доошгүй эрүүл мэндийн үзлэгт хамруулсан гэсэн заалтын дагуу 1-12 дугаар ангийн бүх сурагчдыг эрүүл мэндийн нэгдсэн шинжилгээ, үзлэгт хамруулсан.

Сумын 1-р цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөний хэрэгжилт 10 дугаар сарын 01-ээс 31-ний байдлаар нийт 2185 хүүхэд хүлээн авахаас 1663 хүүхэд авч, ирц 76 хувьтай байна.

Мал амьтныг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуултын ажилд 28900 толгой хурга ишиг, 4200 толгой тугал дархлаажуулалтанд хамруулж тайлан мэдээг хугацаанд нь МЭГазарт хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" зарлиг, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны А/309 тоот захирамжийн дагуу мод тарих өдөр зохион байгуулж цэцэрлэгт хүрээлэнг цэвэрлэх, тарьсан модоо арчлах, услах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хүдэр сүм:

Сумын ИТ-ын ээлжит хуралдаанаар сумын 2019 оны үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан, 2020 оны үндсэн чиглэлийн төслийг хэлэлцүүлэн батлуулснаас гадна сумын өвсний нөөц бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг 10-р сард зохион байгуулах бэлтгэл ажлын талаар болон Тарвагатай багийн нутаг дэвсгэрт баавгай айл руу орж ирсэн асуудлыг тус тус хэлэлцсэн.

Сумын хэмжээнд 2020 оны "Иргэдийн аюулгүй байдлыг бүрдүүлэх жил" болгон зарлалаа.

Олон Улсын ахмадын өдрийг тохиолдуулан сумын ЗДТГ-аас тэтгэвэрт гарсан 14 ахмад настyg хүлээн авч "Хишиг өдөр" арга хэмжээг зохион байгуулсан. Мөн аймгийн эмэгтэйчүүдийн холбооны "Өөдлөн дэвжих цаг" арга хэмжээг тус суманд зохион байгуулагдсан.

Аймгийн Засаг даргын санаачилгаар зохион байгуулагдаж буй "Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоо", хүн амын мэдээллийн цахим санг бүрдүүлэх цог үзлэг тус суманд 10-р сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, үзлэгт 546 иргэн хамрагдсан.

Дэлхийн багш нарын 25, Монголын багш нарын баярыг угтан "Багшлах ур чадвар" тэмцээнийг залуу багш нарын дунд зохион байгууллаа. Тэмцээнд 15 багш оролцсон. Дэлхийн зөн Олон Улсын байгууллага, аймаг орон нутгийн санхүүжилтээр ЕБС-ийн ариун цэврийн байгууламжийг хийж дуусган хүлээж авахад бэлэн болоод байна.

Сургуулийн өмнөх байгууллагад 2019-2020 оны хичээлийн жилд сумын тойргийн 2-6 хүртэлх насны нийт 261 хүүхдээс 243 хүүхэд үндсэн сургалтад хамрагдаж, хамран сургалт 93,0 хувьтай байна.

Тайлант сард байгаль орчны тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хяналт шалгалтын ажлуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Бичил уурхайгаар алт олборлогч нөхөрлөлүүдийн үл ажиллагаанд 5 удаа хяналт шалгалт хийж, "Галуугийн булан" нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, техник тоног төхөөрөмжийг албадан буулгасан. Мөн Шоргоолж гэх газарт зөвшөөрөлгүй алт олборлосон "Маралз" ХХК-ий үйл ажиллагааг зогсоож, Зөрчлийн хуулийн дагуу 10,0 сая төгрөгийн шийтгэл ногдуулж, барагдуулсан.

Сумын малчдын зуслан болон өвөлжөөнд баавгай үзэгдэж, 13 айлын 23 бог, 1 адууг барьж эд материалын хохирол учруулсныг мал хамгаалах ажлын хэсгийг гарган малчидтай хамтран үргээлэг зохион байгуулж, дайжуулах арга хэмжээ авлаа.

Жавхлант сум:

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу Жавхлант нутгийнхаа 130 ахмадад хүндэтгэл үзүүлж олон улсын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүллээ. Азай буурал ахмадуудын дунд гар бөмбөг, хөзөр, хөгжилтэй буухай, "Атар 60" дуун цэнгүүн зэргийг зохион байгууллаа.

Дэлхийн багш нарын 25 дахь, Монголын багш нарын 53 дахь багш нарын баярыг амжилт бүтээлээр дүүрэн тэмдэглэн өнгөрүүллээ. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын багш нарын ажил хөдөлмөрийг үнэлэн нийт 13 багшийг аймаг, сумын Засаг даргын шагнал болон салбарын шагналаар шагнаж урамшуулав.

Өвөл цагийн соёл хүмүүжил мэдээллийн цагийн нээлтийн удирдамжийг боловсруулан төр төсвийн байг ууллагад хүргүүлэн шинээр хэрэгжиж байгаа журмаар илтгэл, ажлын байрны дасгал хөдөлгөөн, төрийн албаны шинэчилсэн хуулиар жүжигчилсэн тоглолтыг зохион байгуулж нийт 73 албан хаагч хамрагдаж тэргүүн байрыг Ерөнхий боловсролын сургууль эзэлж, дэд байрыг 1 дүгээр цэцэрлэгийн хамт олон тус тус хүртлээ.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан залуу малчдын туршлага судлах аялалд тус сумаас 5 малчин оролцлоо.

Хорих ангиас суллагдсан гэр оронгүй 1 иргэнд онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж олголоо. Энэ онд түлээ нүүрсний хөнгөлөлтөнд 5 ахмад, 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 2.240.000 төгрөгийн дэмжлэл, Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн, 1 ахмад настанд нийт 240000 төгрөгийн шүдний хөнгөлөлт эдэлсэн.

Төр төсвийн байгууллагуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Намрын инээмсэглэл" явган аялалыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд ЕБС, 1-р цэцэрлэг, ЗДТГ, Соёлын төв, ЭМТ зэрэг байгууллагуудын нийт 67 албан хаагчдын дунд буухиа тэмцээн, хээрийн цай амттай тэмцээнүүдийг зохион байгуулж нийлбэр дүнгээр 1 дүгээр Цэцэрлэг, 2 дугаар байранд ЕБСургууль шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулав.

Сумын эрүүл мэндийн төв тайлант сард нийт 377 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх 18, амбулаториор 67, гэрийн идэвхитэй эргэлтээр 94, идэвхитэй хяналтаар 32 хүнд хүнд үзлэг хийж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвлөгөө өгч ажиллалаа. Иргэдэд хөнгөлөлттэй эмийн жороор 30 иргэнд үйлчилж зөвлөгөө өгч ажилласан. Сайн дурын томуугийн дархлаажуулалтанд 3-5 настай -4, 5-9 настай -6, 10-15 настай -5, 16-24 настай -1, 25-49 настай -7, 50-64 настай -4, 65-аас дээш настай -3 тус тус хамрагдсан байна.

Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын А/508 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй 2019-2020 оны хичээлийн жилийн гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Багш, сурагчид, эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа, хичээл зүтгэл, нөр их хөдөлмөр, бүтээлч ажлын үр дүн өнөөдөр биелэлээ олж “Эко сургууль” хөтөлбөрийн үндэсний 5 дугаар чуулганд оролцож, Жавхлант ЕБС нь “ХҮРЭЛ ГЭРЭГЭ”-ний болзол хангаж шагналаа гардан авлаа.

Алтанбулаг суманд зохион байгуулагдсан “Ерөө бүсийн соёл урлагийн ажилтны баяр”-т соёлын ажилчид амжилтай оролцоод ирлээ. “Аяыг таа” тэмцээнд 1-р байр, Гар бөмбөгийн тэмцээнд байгуулагаараа 3-р байр, Дардас шидэх тэмцээнд 2-р байр, Урлагийн тоглолтоор 1-р байрыг эзэлж нийлбэр дүнгээр ТЭРГҮҮН байр эзэллээ.

“Бидний хүч хамтын оролцоо” байгууллага сурталчлах 14 хоногийн аяны хүрээнд төр төсвийн байгууллагад үйл ажиллагаатай танилцуулж, ахмад ардын авьяастан МУСТА Х.Халтмаа, Д.Загдхорол, Соёлын төвийн ажилтан Б.Гантөмөр нарт аж ахуйн нэгж удирдлагуудын зүгээс түлээ нүүрсний дэмжлэг үзүүллээ.

Сумын хэмжээнд ургац хураалтын явц 95 хувьтай байна. Үүнд: улаанбуудай 8411 га талбайгаас 10241 тн, рапс 1829 га талбайгаас 695 тн, Төмс 38 га талбайгаас 640 тн, 105.5 га талбайгаас 1485 тн ургац хураан аваад байна.

Атар 60 жилийн ойг тохиолдуулан сумын Засаг даргын Тамгын газар, Залуучуудын холбоотой хамтран “Нар дагуулсан намрын өдөр” сайн үйлсийн аяныг зохион байгуулж, 25 төрийн албан хаагчид нэгдэж “Хурниад” ХХК, “Бадрал оргил” ХХКомданиудын нэг өдрийн тариа хураалтын ажилд тусаллаа.

Аймгийн хөрөнгө оруулалтаар Бумбат 1-р багийн Шарын голын тохойн 5.0 га газарт ойн зурвас байгуулах ажлыг Ерөө бүсийн сум дундын ойн анги хийж гүйцэтгэсэн.

Тус сумын Моностой 2-р багийн Ерөө голын урд Ногоон тохой гэх газарт идэш тэжээлийн хомсдолд орсон залуу баавгай, бамбарууш нийлсэн 3 тооны ойн хүрэн баавгай намаржаандаа байгаа малчин айлын хотруу орж гэр барааг нь эвдэж сүйтгэх, айраг цагааг нь ууж идэх, ямаа нохойг нь идэх зэрэг малчдыг сандаргаж байгаа тохиолдол удаа дараа тохиолдсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлиг, Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд нийт 25 иргэд хашаандаа 7 нэр төрлийн 60 ширхэг гоёлын мод, 4-н нэр төрлийн 60 ш жимсний мод нийт 120 ш мод бутийг тариж суулган ногоон орчинг бий болгоод байна.

Түшиг сүм:

Хүн ам өрхийн мэдээллийн санг баяжуулж, 2019 оны байшин орон сууцны тооллогоор нийт 574 сууц тоолж гүйцэтгэж, тайлан мэдээг хугацаанд нь гарган аймгийн Статистикийн хэлтэст тайлагналаа.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 8 дугаар хуралдаанаар Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг тайлагналаа. Үүнд: Архив, албан хэрэг хөтлөлтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хүүхэд хөгжил хамгаалал хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг тавьсан.

Тайлант сард аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалт 9 чиглэлээр хийгдэж, сумын хэмжээнд сайн үнэлэгдлээ. Мөн аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар ажиллаж хамтарсан багийн бүрэлдэхүүнд сургалт явуулж, зорилтот өрхийн гишүүдэд зориулсан олон төрөлт арга хэмжээг явууллаа.

“Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ” аймгийн аяны хүрээнд төрийн албан хаагчид иргэдэд албан тушаалын чиг үүрэг болон салбарын хэмжээнд хийгдэж буй ажил үйлчилгээг хуваарийн дагуу тайлагнаж байна.

2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд сумын хэмжээнд өвс 5935 тонн, ногоон тэжээл 315 тонн, үйлдвэрийн тэжээл 1583 тонн, байгалийн хадлан 6000 тонныг бэлтгэж, төлөвлөгөөг 100% биелүүллээ.

Сумын ургацын мэдээгээр 10 дугаар сарын 20-ны байдлаар блаан буудай 7671 га талбайгаас 1958 га талбай хураан 2470 тонн, овьёос 1009 га талбайгаас

230 га хураалт хийснээс 230 тонн, рапс 2767 га талбайгаас 882 га талбай хураалт хийснээс 472,6 тонныг хураан авч сумын дүнгээр ургац хураалт нэгж га-с 12,6 цн буюу 30 хувьтай байна.

Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх үзлэгээр 148 буюу 71,1 хувь, гэрийн идэвхтэй эргэлт 41 буюу 19,7 хувь, түргэн тусламжийн 28 үүнээс алсын 8, ойрын 20 дуудлага бүртгэгдлээ. Эмнэлэгт 5 хүнийг хэвтүүлэн эмчилж, нийт 4 эх төрснөөс сумандаа 1, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 3 эхийг төрүүллээ. Жирэмсний хяналтанд 16 эх хянагдаж байна. Товлолт дархлаажуулалтанд 15 х/т вакцин дархлаажуулж дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй байна.

“Гар угаах Дэлхийн өдөр”- ийг тохиолдуулан ЕБДС 1,2,3 дугаар ангийн сурагчдад гарыг зөв угаах талаар сургалт хийж, Моносхон 27-р цэцэрлэгийн эмчтэй хамтран 2 бүлгийн 40 гаруй хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА